

ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ХЯНАН ЗОХИЦУУЛАХ ҮҮРЭГ БҮХИЙ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ШИНЭЧЛЭН НАЙРУУЛСАН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга /цаашид “санаачилга” гэх/-ыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөл /цаашид “Үндэсний зөвлөл” гэх/ нь Засгийн газрын байгууллага, төрийн холбогдох байгууллага, олборлох үйлдвэрлэл эрхлэгчид, төрийн бус байгууллагын төлөөлөл бүхий зөвшилцөн шийдвэр гаргадаг зөвлөл мөн.

2. Үндэсний зөвлөлийн зорилго нь санаачилгын үндсэн зарчим, шалгуурыг ханган хэрэгжүүлэх, түүнийг цаашид гүнзгийрүүлэн хөгжүүлэх улс төр, эрх зүй, зохион байгуулалтын бодлого, нөхцөлийг Монгол Улсад бүрдүүлэх явдал мөн.

3. Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

Хоёр. Үндэсний зөвлөлийн зохион байгуулалт

4. Үндэсний зөвлөлийн дарга нь Монгол Улсын Ерөнхий сайд, орлогч дарга нь Уул уурхайн сайд байна.

5. Хуралдааны чөлөөт цагт Уул уурхайн сайд эрхэлсэн ажлынхаа хүрээнд санаачилгыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хянан зохицуулах үүргийг Үндэсний зөвлөлийг төлөөлөн удирдаж, зохицуулан явуулна.

6. Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд орох Засгийн газрын байгууллага, ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ бүхий аж ахуйн нэгж, тэдгээр аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан ажиллаж байгаа туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгж (цаашид “компаниуд” гэх)-үүд, салбарын мэргэжлийн холбоо (цаашид “мэргэжлийн холбоо” гэх), олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг хангах чиглэлээр эвлэлдэн нэгдсэн иргэний нийгмийн эвсэл (цаашид “иргэний нийгмийн эвсэл” гэх)-ийн төлөөллийн тоог Засгийн газар адил тэгш байдлаар тогтооно.

7. Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүний төлөөллийг дараахь байдлаар томилж, чөлөөлнө:

7.1. Үндэсний зөвлөлд орох Засгийн газрын байгууллага, Улсын Их Хурал, түүний харьяа байгууллагаас төлөөллийг Ерөнхий сайд томилж, чөлөөлнө.

7.2. Үндэсний зөвлөлд орох компаниуд, мэргэжлийн холбоод, газрын тосны салбарт бүтээгдэхүүн хуваах гэрээтэй аж ахуйн нэгжийн төлөөллийг Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн ерөнхийлөгч томилж, чөлөөлнө.

7.3. Үндэсний зөвлөлд орох иргэний нийгмийн эвслийн төлөөллийг Иргэний нийгмийн “Төлсөн авснаа нийтэл” (цаашид ТАН гэх) эвслийн зохицуулах зөвлөлийн хурлаар, байгаль орчны иргэний нийгмийн эвслийн төлөөллийг тус эвслийн удирдах байгууллагын хурлаар тус тус хэлэлцэн томилж, чөлөөлнө.

8. Засгийн газрын төлөөллийн ахлагч нь Уул уурхайн сайд, компаниудын төлөөллийн ахлагч нь Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн ерөнхийлөгч, иргэний нийгмийн төлөөллийн ахлагч нь “ТАН” эвслийн зохицуулагч байна.

9. Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга нь Монгол Улсын Ерөнхий сайдын ахлах зөвлөх байна. Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга нь зөвлөлийн гишүүний нэгэн адил эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

Гурав. Зөвлөлийн хуралдаан

10. Үндэсний зөвлөл шаардлагатай үед Үндэсний зөвлөлийн даргын, түүний эзгүйд Уул уурхайн сайд, тэдгээрийн эзгүйд орлож байгаа гишүүний зөвшөөрснөөр хуралдана. Хуралдааны бэлтгэлийг Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга хангана.

11. Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг Үндэсний зөвлөлийн дарга, Уул уурхайн сайд, түүний эзгүйд орлож байгаа гишүүнд танилцуулж, материалыг хуралдаанаас 3-оос доошгүй хоногийн өмнө гишүүдэд цахим хэлбэрээр хүргүүлнэ. Шаардлагатай зарим материал, Монгол Улсын ОУИТБС-ын .. оны тайланг бичгээр заавал хүргүүлнэ.

12. Үндэсний зөвлөлийн хуралдаадзохих гишүүдийн тоог оролцогч бүрээс 6 гишүүн ирсэн байх тохиолдолд хуралдааныг хүчинтэйд тооцох болно. Хуралдаанд албан ажлын болон бусад шалтгаанаар оролцох боломжгүй гишүүн саналаа бичгээр ирүүлж болно. Бичгээр саналаа ирүүлсэн гишүүнийг хуралд ирснээр тооцно. Гишүүний бичгээр ирүүлсэн саналыг хуралдаан даргалагч гишүүдэд танилцуулж, шийдвэр гаргахад харгалзан үзнэ.

13. Хуралдааныг Ерөнхий сайд удирдан явуулах бөгөөд түүнийг эзгүйд Уул уурхайн сайд, эсхүл үндэсний зөвлөлийн оролцогч талуудын аль нэг ахлагч удирдан явуулна.

14. Үндэсний зөвлөл хуралдаанаас тэмдэглэл гаргана. Үндэсний зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийг Ажлын албаны зохицуулагч хөтөлнө. Тэмдэглэлд Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, Ажлын албаны зохицуулагч нар гарын үсэг зурж албажуулна.

Дөрөв. Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудал

15. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа асуудлыг ажлын хэсэг эхлэн боловсруулан хэлэлцэж, улмаар Үндэсний зөвлөлд оруулж байна.

16. Үндэсний зөвлөлийн гишүүн хуралдаанд асуудал боловсруулан хэлэлцүүлэх, хэлэлцэх асуудлын талаар санал гаргах эрхтэй. Гишүүн хуралдаанаар хэлэлцүүлэхээр боловсруулсан асуудлаа Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн даргад өгч хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулж гишүүдэд хүргүүлнэ.

17. Үндэсний зөвлөлийн хуралдаанаар дараахь асуудлыг хэлэлцэнэ:

17.1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан ажлын хэсгээс боловсруулсан асуудал, тогтоол шийдвэрийн төслүүд;

17.2. Монгол Улсын ОУИТБС-ын .. оны тайлан;

17.3. Үндэсний зөвлөлийн ажиллах журам, ажлын хэсгийн тайлан, мэдээлэл;

17.4. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан сайд, агентлагийн удирдлагын мэдээлэл, санал;

17.5. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх, хөгжүүлэхтэй холбоотой хууль тогтоомж, шийдвэрийн төслийг боловсруулах талаар чиглэл өгөх асуудал;

17.6. Хуралдаанаар хэлэлцэх шаардлагатай гэж үзсэн бусад асуудал.

Тав. Үндэсний зөвлөл дэх зөвшилцлийн хэлбэр

18. Үндэсний зөвлөлийн хуралдааны үед санал зөрүүтэй, маргаантай асуудал гарвал дараахь арга хэлбэрээр зөвшилцөнө:

18.1. Оролцогч талуудын ахлагч нар тухайн асуудлаар зөвшилцөх;

18.2. Үндэсний зөвлөл нь талуудын хооронд санал зөрүүтэй, маргаантай асуудлаар эрдэмтэн, зөвлөх, шинжээчдийн баг томилж санал, дүгнэлт гаргуулах;

18.3. Тухайн асуудлыг ОУИТБС-ыг хэрэгжүүлэх үүрэгтэй ажлын хэсгээр дахин боловсруулж, хэлэлцүүлэхээр шийдвэрлэх.

18.4 Шийдвэр гаргахад санал зөрөлдөх тохиолдолд санал хураах боломжийг нээж байгаа бөгөөд үүгээр санал хурааж, шийдвэрийн хүчинтэй байх дүн нь тухайн асуудлаар хуралдаанд оролцсон төлөөлөл бүрийн 2/3- оос доошгүй тооны гишүүдийн санал авсан байх ёстой.

Зургаа. Үндэсний зөвлөлийн хуралдаанаар шийдвэрлэсэн асуудлыг албажуулах хэлбэр

19. Үндэсний зөвлөлөөс дараахь хэлбэрээр шийдвэр гаргахыг зөвлөнө:

19.1. Тухайн асуудлаар Ерөнхий сайдын захирамж гаргах;

19.2. Хууль тогтоомжийн төсөл, эсхүл Засгийн газрын тогтоолоор шийдвэрлэх шаардлагатай асуудлыг Засгийн газрын хуралдаанд оруулах;

19.3. Тухайн асуудлыг холбогдох хууль тогтоомжоор бүрэн эрх бүхий Үндэсний зөвлөлийн аль нэг гишүүнд уламжлан шийдвэрлүүлэх, хяналт шалгалт хийлгэж үр дүнг сонсох;

19.4. Үндэсний зөвлөлийн оролцогч талуудын хамтарсан шийдвэр, зөвлөмж гаргаж, нийтэд мэдээлэх.

Долоо. Үндэсний зөвлөлөөс тавих хяналт

20. Үндэсний зөвлөл гаргасан шийдвэр, өгсөн үүргийн биелэлтээ гаргуулж гишүүдэд танилцуулах, шаардлагатай бол хуралдаанаар хэлэлцэх бөгөөд хуралдааны чөлөө цагт Үндэсний зөвлөлийн дарга, эсхүл орлогч дарга танилцаж чиглэл өгнө.

21. Үндэсний зөвлөлийн гаргасан шийдвэрийн биелэлт болон олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлж байгаа байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд гишүүд, ажлын хэсэг хяналт тавина.

22. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх чиглэлээр Ажлын хэсгээс хийж байгаа үйл ажиллагааны явц, биелэлттэй Үндэсний зөвлөлийн орлогч дарга, гишүүд танилцаж, явцыг эрчимжүүлэх арга хэмжээ авна.

23. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэхтэй холбогдсон зарим асуудлаар эрдэмтэн, мэргэжилтэн, зөвлөх оролцсон шинжээчийн хэсэг байгуулж дүгнэлт гаргуулж болно.

Найм. Бусад

24. Үндэсний зөвлөлийн бичиг хэргийн зардлыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Уул уурхайн яам, ажлын алба хариуцна.

25. Үндэсний зөвлөл нь Засгийн газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Уул уурхайн яамны албан бичгийн хэвлэмэл хуудас, тамга, тэмдгийг хэрэглэнэ.

26. Үндэсний зөвлөлийн гишүүд Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын лого бүхий нэрийн хуудастай байна.